



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/478

Зуунмод

Хяналтын камерын тооллого зохион
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дах заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Зуунмод сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид ашиглагддаг теле хяналтын камер /гадна, дотор, авто замын/-ын тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2.Теле хяналтын камерын тооллогын ажлыг үр дүнтэй, хурдан шуурхай зохион байгуулан 2022 оны 12 дугаар сарын 26-ны дотор тайлагнаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэн (Д.Амартүвшин), Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн (Д.Гэрэлтогтох), Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн (Ч.Цогтмягмар), зохион байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэн ажиллахыг багийн хэсгийн байцаагч, багийн хэсгийн ахлагч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тооллогын ажилд идэвх санаачилгатай хамтран оролцохыг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын дарга, эрхлэгч, үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (Н.Энхсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.САРАНГЭРЭЛ